

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 06 дугаар сарын 23-ны өдөр, Даваа гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-15

1.Монгол Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ 4-14

2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Байнгын хорооны тогтоолд өөрчлөлт оруулах тухай/ 14-15

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 06 дугаар сарын 23-ны өдөр
/Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 37 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Д.Батлут, Ж.Ганбаатар, Г.Дамдинням, П.Мөнхтулга, Г.Тэмүүлэн;

Нэг.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Л.Батмөнх, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваа, З.Мэндсайхан, Р.Батболд, Ж.Батжаргал нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн үг хэлэв.

Ц.Даваасүрэн: Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 4
Бүгд: 18
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Байнгын хорооны тогтоолд өөрчлөлт оруулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Даваасүрэн: “Байнгын хорооны тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 38 минут үргэлжилж, 25 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 76.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 15 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 23-ны өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
13 цаг 37 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг эрье.

Байнгын хороонд хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 ирц 56 хувьтай байгаа учраас Төсвийн байнгын хорооны 2025 оны 6 сарын 23-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Ирсэн гишүүдийг танилцуулъя. Ирцийг та бүхэнд танилцуулъя. Миний бие ирсэн байна Р.Батболд гишүүн, Б.Батцэцэг гишүүн, Ж.Баясгалан гишүүн, Х.Болормаа гишүүн, Г.Ганбаатар гишүүн, П.Ганзориг гишүүн, Б.Заяабал гишүүн, Б.Мөнхсоёл гишүүн, З.Мэндсайхан гишүүн, Б.Түвшин гишүүн, Б.Чойжилсүрэн гишүүн, Т.Аубакир гэсэн гишүүд бүртгүүлсэн байна. Булгантуяа гишүүн.

Хэлэлцэх асуудлыг би та бүхэнд танилцуулъя. 2 асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн байгаа. Эхний асуудал Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл. Өмнө нь хэлэлцэж байсан хууль байгаа шүү дээ. Санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын нэгдсэн чуулганд танилцуулна.

Хоёрт, Байнгын хорооны тогтоолын төсөл тогтоолд өөрчлөлт оруулах тухай гээд. Энэ Санхүүгийн зохицуулах хорооны нэр дэвшигчийн хэлэлцүүлэг хийх тухай ийм тогтоолын төсөл байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад санал хэлэх гишүүн байна уу?

Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Эхний асуудал, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн нар оролцож байна.

Гаалийн албан татварын чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцогдох хуулийн төслийн талаарх танилцуулгыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр танилцуулна. 4 номерын микрофон.

Ж.Энхбаяр: Эрхэм Байнгын хорооны гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хэлэлцэн, улаан буудайн гурил, мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийг гаалийн албан татвараас чөлөөлж, тоо хэмжээний болон хугацааны хязгаарлалтгүй импортлохоор эцэслэн баталсан.

Хууль хэрэгжиж тухайн цаг үеийн хүндрэлтэй нөхцөл байдалд хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах зорилгодоо хүрсэн учраас Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болгох тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн барьж, хэлэлцүүлсэн боловч дэмжигдээгүй юм.

Энэ хуулийн үйлчлэл зөвхөн улаан буудайн гурил үйлдвэрлэгчдийн үйл ажиллагаанд бус хөдөө аж ахуйн салбарын суурь үйлдвэрлэл болох газар тариалан, мал аж ахуйн болон тэжээлийн үйлдвэрлэл, түүнчлэн техник, тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис, бордооны ханган нийлүүлэлтийн үйл ажиллагаа зэрэг хөдөө аж ахуйн нийлүүлэлтийн сүлжээнд тогтворгүй нөхцөл байдлыг бий болгож байна.

Хүнсний тухай хуулиар Монгол хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай малын мах, сүү, тарианы үр, улаан буудай, гурил, ундны усыг стратегийн хүнс гэж тодорхойлон эдгээр хүнсний дотоодын үйлдвэрлэл, хангамжийг тогтвортой байлгах, улирлын болон улсын нөөц бүрдүүлэх, импортын хямралыг бууруулахад чиглэсэн арга хэмжээг төрөөс хэрэгжүүлдэг.

Өөрөөр хэлбэл, Монгол хүний анхдагч суурь хүнсний хэрэглээ нь стратегийн хүнс бөгөөд эдгээрийг дотоодын үйлдвэрлэлээр хангах чадавхтай байх нь манай улсын хүнсний аюулгүй байдлын баталгаа төдийгүй үндэсний аюулгүй байдлын нэгэн чухал илэрхийлэл гэж үзэж болно.

Цаашид энэхүү хуулийн үйлчлэл хугацаагүй үргэлжлэх нь стратегийн хүнсний үйлдвэрлэл, хангамжийн тогтолцоог гажуудуулж, улмаар Монгол Улсын хүнсний баталгаат аюулгүй байдлын эрсдэлт эмзэг нөхцөл байдлыг нэмэгдүүлэх болно.

Мөн гаалийн албан татварыг үргэлжлүүлэн чөлөөлөх Монгол Улсын Ерөнхийлөгч санаачилж Улсын Их Хурлаар баталсан “Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын Атрын 4 дүгээр 4 дүгээр аян, Тариалангийн тогтвортой хөгжил зэрэг дунд хугацааны бодлогын хэрэгжилтэд уялдахгүй бөгөөд хүнс, хөдөө аж ахуйн салбарт оруулсан хөрөнгө оруулалтын үр дүнд сөргөөр нөлөөлж, аж ахуйн нэгж үйлдвэрлэгч, малчид, тариаланчдыг өрийн дарамтад оруулах, хөдөөд ажлын байрыг бууруулах, хот сууринд шилжин ирэх хүн амын нягтрал нэмэхэд түлхэц болохоор байна.

Хүнс, хөдөө аж ахуйн салбарт биднээс үл хамааран байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлт, олон улсын харилцаа, эдийн засгийн ээдрээтэй бөгөөд таамаглашгүй нөхцөл байдлаас олон эрсдэл учирдаг. КОВИД цар тахлын сорилтууд бидэнд бие даасан, тогтвортой тэсвэртэй, даван туулах хүч чадалтай байх сургамжийг өгсөн саяхан.

Улсын хэмжээнд 2025 оны хаврын тариалалт 6 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар 470 мянган га буюу 73.2 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд тариалалтын технологид хугацаа дууссан энэ үед улаан буудай 264 мянган га буюу 85.3 хувийн гүйцэтгэлтэй гарч байна.

Гадаад улс орны геополитикийн нөхцөл, улс төрийн хурцадсан байдал, Оросын Холбооны Улсаас баримталж буй төрийн бодлого шийдвэрийн хүрээнд тодорхойгүй хугацаагаар улаан буудай малын тэжээлийн экспортыг хязгаарласан, түүнчлэн валютын ханшийн өөрчлөлт зэргээс шалтгаалан импортын гурилын үнэ өсөх нөхцөл үүсэж байна. Иймээс хөдөө аж ахуйн салбарт үүссэн бодит байдлыг үндэслэн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулсан болно. Импортын хараат байдлаас ангижрах бодлогыг цаг ямагт хэрэгжүүлэх нь үндэсний эрх ашгийг хангах тусгаар улсын үүрэг бөгөөд цаашид импортын гурилын үнэ дотоодод үйлдвэрлэсэн гурилын үнээс хямд байх баталгаа байхгүй тул Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болгох тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Даваасүрэн: Энхбаяр сайдад баярлалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулаад хууль санаачлагчаас асуух асуулттай гишүүдийн нэрсийг авъя.

Пүрэвдаваа гишүүнээр тасалъя. Тийм ээ энэ өмнө нь хэлэлцэж байсан асуудал байгаа. Ирцийн дараалалд ордог юм уу, орох юм болов уу яах юм бол? Пүрэвдаваа гишүүн ирц бүртгүүлсэн дээ. Пүрэвдаваа гишүүн асууж байя. Асууж бай асууж бай .

Д.Пүрэвдаваа: Өглөөний мэнд. Би хууль зүйн хувьд юм асуух гээд байна. Юу гэхээр зэрэг Улсын Их Хурлаар энэ төсөл маань уначихсан. Тэгээд тодорхой ердөөсөө төд удалгүй байдлаар дахин дахин оруулаад ирж байгаа нь зайлшгүй л шаардлагатай байна гэж харж байгаа юм. Эрх зүйн хувьд өөрөө энэ миний хувьд асуух гээд байгаа нь Улсын Их Хурал унагаачихсан хуулиудыг ер нь хэдий хугацаанд эргүүлж оруулж борлодог юм? Ер нь зарчмын хувьд энэ асуудлыг дэмжиж байгаагаа илэрхийлж байна. Энэ хуулийн төсөл нь уг нь хэрэгцээтэй байсан уу, хэрэгцээтэй байсан. Тэгэхдээ унагаачихдаг. Одоо дараа дараагийн бүх энэ унасан хуулийн төслүүд хэдий хугацаанд ер нь хууль зүйн хувьд ингэж орж ирж явж байх ёстой юм бэ? Энийг би асууж гэж бодсон юм. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Ерөнхийдөө чи наадах чинь Их Хурлын л, Их Хурал руугаа л хандсан юм болчихоод байна л даа. Ер нь тийм зохицуулалт байхгүй байх. Манай Тамгын газраас зүгээр лавлагаа өгөх юу байна уу? Манай Тамгын газар ер нь хуулийн лавлагаа л өгнө үү гэхээс биш тэр хууль зүйн дүгнэлт гаргаж байгаа цэц шиг энэ тэр юмаа болих хэрэгтэй. Байж болохгүй шүү дээ. Хууль дээр тайлбар, дүгнэлт гаргах юм чинь Дээд шүүх, Цэцийн асуудал байдаг болохоос биш манай Тамгын газар орж ирээд л хууль тайлбарлаад байж болохгүй. Зүгээр энэ дээр лавлагаа өгч болно. Хууль дээр ийм байна гэж. Манай хуулийн хэлтсээс хүн байна уу? Хариулах уу айн? Байхгүй байхгүй.

Энхбаяр сайд тэр талаар та хэд хууль өргөхдөө харсан юм байгаа юу? Сар болоогүй байхад буцаад өргөлөө. Хуулийн зохицуулалт байдаггүй юм уу гээд асуугаад байгаа юм байна л даа. 4.

Ж.Энхбаяр: Бидэнд ганц байгаа хязгаарлалт нь Ерөнхийлөгч хориг тавих 5 хоног л байгаа. Тэрнээс ямар нэгэн хууль тогтоомжоор дахин өргөн барих асуудлыг хязгаарласан зүйл байхгүй. Байхгүй ерөөсөө тийм зохицуулалт байхгүй. Өргөн барьж болно, хэлэлцүүлж болно.

Ц.Даваасүрэн: Мэндсайхан гишүүн асуултаа асууя.

З.Мэндсайхан: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр энэ хуулийн төслийг дэмжиж байна. Энхбаяр сайдаас асуух асуулт байна. Энэ жилийн энэ тариалалт, үр тарианы хувьд энэ хуулийн үйлч, өмнө гарсан хуультай холбоотойгоор тариалалт буурсан гэж яриад байгаа. Энэ яагаад энэ хүнсний ногоон тариалалт 55 хувьтай байна. Энэ өмнөх жилийн дунджаар байна уу? Ингэж огцом буурч уу? Буурсан бол ямар шалтгаанаар энэ хүнсний тариалалт буурчхав? Хүнсний ногооны тариалалт?

Хоёрдугаарт, та энэ тарааж өгсөн материал дээр ерөнхийдөө намар бид нарт гурилын үйлдвэрлэлд улаан буудайн дутагдал үүсэх нь тодорхой болсон. Тэгэхээр энийг импортоор авна гэж байна л даа. Энэ та бүгдийн хийсэн тооцооллоос харахаар 140-50 мянган тонн улаан буудай хэрэгтэй болно гэж байна. Энэ жил нэгэнт бид нар улаан буудайн тариалалт бас буурсан. Ний нуугүй үнэнийг хэлэхэд нийт тариалалтын маань улаан буудайн тариалалтын чинь намар ургац хураалтын үр дүнгээр 30 хүрэхгүй хувь нь л үйлдвэрлэлт тэнцдэг шүү дээ. 70 хувь нь тэнцдэггүй. Тэгэхээр таны хэлж байгаа тоо хэмжээ нэмэгдэнэ шүү.

Ийм учраас энэ жил, энэ зуныг тариалалтын энэ технологийн хугацаанд тариалсан тэр жоохон будааныхаа чанарын талд нь та хэд маань яаж хамтарч ажиллах гэж байна? Энэ аж ахуйн нэгжүүдтэйгээ нэлээн ойлголцож байж энэ импортын асуудлыг нээхгүй бол дотоодын үйлдвэрлэл маань чанарын шаардлага хангахгүй гэдэг асуудал үүснэ. Энэнтэй холбоотойгоор л элеваторуудын чинь лабораториудын асуудал гарч ирээд л гурилын үйлдвэрүүд өөр өөрийн лабораториороо өөр өөрийн дүгнэлт гаргаад тариаланч дээр тоглоод эхэлнэ. Тэгэхээр энэ лавлагаа, лаборатори дээрээ үндэсний лавлагаа, лаборатори дээрээ бүгдийг нь стандартыг нь тогтоогоод явах энэ чиглэл рүү нь та бүгд маань ажиллаж байна уу? Ийм 2 асуудлыг л асуучихмаар байна.

Хөдөө аж ахуйн сайд байсан хүний хувьд доторх юмыг нь сайн мэдэж байгаа байх л даа. 4 номерын микрофон Энхбаяр сайд лаборатори бий юу гээд.

Ж.Энхбаяр: Нийт хураан авсан улаан буудайн 65-70 хувь нь гурил болдог. Тухайн жилийнхээ чанараас шалтгаалаад. Ноднингийн бид нар нөөц бас манай хөдөө аж ахуйн корпорац дээр улсын нөөцийн бодлогыг барьдаг 46 мянган тонн улаан буудайн нөөцтэй байна. Энэ жил энэ хуультай холбоотойгоор улаан буудайн тарилт 100 гаруй мянган га-гаар багасчихсан. Энэнтэй холбоотойгоор бид нар 120-130 мянган тонн улаан буудайг импортоор авахаас аргагүй байдал үүснэ. Лабораторитой холбоотой, ноднин бид бүх лабораториуд тоног төхөөрөмж жигдэрсэн. Ноднин чанар дээр холбоотой ямар нэгэн гомдол гараагүй. Энэ лабораториудад дахин бид нар итгэмжлэх энэ 7 сардаа багтаад итгэмжлээд

жигдлээд дахин тохиргоог нь хийгээд янзалчихна. Энэ бол нэлээн жигдэрчихсэн ажил, арга хэмжээ болчихлоо.

Ноднин хууль гарахад бид 443 мянган га тарьж байсан тариалалт маань ноднин 386 болж унасан юм. Яг тариалалтын үед энэ хууль гарсан. Энэ жил засагдчих гэж нэлээн хичээгээд яг тариалалтын үед бас энэ хуулийг батлахгүй гээд ахиад Их Хурал дээр унасан. Үүнээс болоод улаан буудайн үйлдвэр 249 мянган га л уначхаж байгаа юм. Бид нар 550,166 мянган га тарьж дотооддоо гурил үйлдвэрлээд 100 хувь хангаж байсан энэ 20, 21, 22 оны амжилтаасаа 23 оны амжилтаасаа огцом ийм уналт үзүүлж байна. Үндсэндээ гурилынхаа 50 хувийг импортоос авахаас өөр аргагүй байдал бий болчихсон. Тэгэхээр энэ ирэх жилийн улаан буудайн үйлдвэрлэлийг бэлдэхийн тулд энэ газар тариалангийн компаниуд хөрөнгө оруулалт хийж, талбай, хөрс технологио бэлддэг.

Тэгэхээр энэ технологит ажлыг тасалдуулахгүйн тулд энэ хуулийг өөрчлөөд ирэх жилийн гурилын улаан буудайн үйлдвэрлэл дээр нэлээн ахиц гаргахын тулд ингэж хийж байгаа юм. Хэдийгээр хожимдсон ч гэсэн. Тэгэхээр бид сан дээр байгаа 46 мянган тонн гурилын үйлдвэрүүд дээр 20 гаруй мянган тонн байна энэ жилийн ургацаа гээд тооцоход бид яах аргагүй 100-120 мянган тонн импортоос авахаар аргагүй байдал үүссэн.

Дээрээс нь ангийн байдал нэлээн нөлөөлж байна. Газар тариалангийн бүс нутагт хэт халалтад 10 дахь хоногтоо явж байна. Яг энэ халалттай холбоотойгоор төмс, хүнсний ногооны тариалалт, хэмжээ бас үндсэндээ 50 хувиар унаад байна. Тэгэхээр бид энэ жил эртхэн бодлого гаргаж хүнсний тогтвортой байдлыг хангах чиглэлээр нэлээн өргөн барих 26 оны төсөв дээр нэлээн бодлогын арга хэмжээн давахгүй жоохон хүндрэл үүсэх нь тодорхой болсон. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Тодруулъя. Мэндсайхан гишүүн.

Ж.Энхбаяр: Энхбаяр сайдаа би хуулийн хувьд дэмжээд байгаа юм. Гол нь та сая 120-оос, 110-120 мянган тонн улаан буудай импортоор авах нь ээ гэдэг, энэ эрсдэл үүсгэнэ гэж яриад байна шүү дээ. Яг одоо миний авсан мэдээлэл дээр газар тариалангийн бүс нутаг маань нэлээн хуурайшилттай байгаа гэж сонсоод байгаа юм.

Тэгэхээр нэгэнт намар импортоор улаан буудай авах нь тодорхой болчихоор нөгөө гурилын үйлдвэрүүд чинь жоохон юм тарьсан тариаланч дээрээ товлоод эхэлнэ. Тэн дээр л та бүгдийг маань анхаараач гэж хэлээд байгаа юм. Жоохон юм тарина тэрийг нь чанарын шаардлагаар нь унагааж аваад л хаашдаа улаан буудай импортоор орж ирнэ гэдэг.

Хоёрдугаарх том асуудал нь юу вэ гэхээр зэрэг энэ тооцоолоод байгаа тооцооллоос чинь давна шүү яг үнэндээ бас эрсдэл нь тэгж харагдаж байгаа шүү. Тэгэхээр импортын хэмжээ чинь нэмэгдэнэ шүү. Тийм учраас та бүгд маань энэ тооцоолол дээрээ илүү анхаараарай. Яг сан дээр байгаа 42 мянган тонн гурил чинь хэддүгээр зэрэглэлийн будаанууд байна? Яг хэдэн тонн? Энэ дээр тоо өгөөч.

Ц.Даваасүрэн: Энхбаяр сайд 4 номерын микрофон.

Ж.Энхбаяр: Одоо байгаа сан дээр байгаа 46 мянган тонн бол 3, 4 дүгээр ангиллын улаан буудай буюу үйлдвэрлэлийн түүхий эдүүд байгаа. Энэ нэлээн

бидэнд бас нөхөөс болно. Тариаланчид үйлдвэрлэгчид ер нь хамтын ажиллагаагаа нэлээн уялдуулж байгаа. Саяын энэ хууль, эрх зүйн орчныг өөрчлөлттэй, сургамжтай холбоотойгоор энэ тариалалтын бодлого, үйлдвэрлэлийн бодлогоо уяж байгаа. Яам өөрөө Тариаланчдын үндэсний холбоо, Гурил үйлдвэрлэгчдийн үндэсний холбоотойгоо хамтраад үйл ажиллагааны хувьд ямар нэгэн ойлголцолгүй хамтын ажиллагаатай хийх юм, үг, хэл нэг ийм байр сууринд оччихсон байгаа. Тэгэхээр ямар нэгэн зөрчил гарахгүй. Таны хэлсэн энэ гангийн байдлын өөрчлөлттэй холбоотойгоор эрсдэлийн хэмжээ нэмж магадгүй. Тэгэхээр энэ 7 сарын энэ хур борооны байдлаас нэлээн олон шийдэл гарах байх.

Ц.Даваасүрэн: Болчихсон уу?

Ж.Энхбаяр: Болсон болсон.

Ц.Даваасүрэн: Тэр түрүүний Пүрэвдаваа гишүүний асуултад бас нэмэлт тодруулга өгье. Хэлэлцэх эсэхийг дэмжих үү, дэмжихгүй юу гээд үзэл баримтлалын хүрээнд санал хураалт явдаг шүү дээ. Тэн дээр уначихсан байх юм бол 1 жилийн дотор өргөхгүй гэж байгаа юм. Тэрнээс биш хэлэлцээд батлах явцад унасан бол зохицуулалт байхгүй юм байна лээ. Дахиж өргөж болох юм байна лээ шүү.

Батболд гишүүн асуултаа асууя.

Р.Батболд: Өдрийн мэнд хүргэе та бүхэнд. Бид нар ниргэсэн хойно нь хашхирав гэдэг л юм хийгээд байгаа юм. Сар гарангын өмнө энэ энэ хууль нь орж ирэхэд батлаад гаргаад явуулчихсан байсан бол өнөөдөр улаан буудайн тариалалт маань бас арай илүү га талбайд явах байсан болов уу л гэж хараад байгаа юм. Одоо бол бид нар 21 оноосоо хойш энэ чинь 260 мянган га-гаар буурчихсан байгаа байхгүй юу тариалалт. Жил жил буураад байна, одоо тариалалт яг явах гээд байна яах юм бэ гээд л Хөдөө аж ахуйн сайд та хэд энэ шийдвэрийг гаргаад өгөөч ээ гээд л байсан. Тэрийг нь аваачаад унагаагаад хаячихсан. Энэ бид нар стратегийн хүнс энэ хүнсний аюулгүй байдал гэдэг юм уу энийгээ бас Улсын Их Хурлын гишүүд бодож баймаар байгаад байгаа юм. Их Хурал дээр хэлээд хэлээд дийлээгүй.

Тэгээд энэ чинь бид нар гурилаа хүнээс гуйж, худалдаж авч иддэг ийм л улс руу л түлхээд оруулчхаж байгаа юм. Баруун, зүүн бүсийн хэдэн гишүүд маань байсан. Тэнд маань энэ хууль гараад гурилын үнэ хямдарчихсан юм гэсээр байгаад л унагаачихсан шүү дээ ер нь. Сүүлдээ бүр гуйж авч байдаг л түвшинд хүргээд байна. 110, 120 мянган тонн улаан буудай импортлох болчихлоо гэж яриад байна шүү дээ. Яг үүгээрээ 26 оныхоо гурилын хэрэгцээгээ яг хангаж хүрэх үү гэдэг асуудал нэгдүгээр асуудал байна.

Хоёрдугаарт нь одоогоос энэ улаан буудайн тариалаагүй талбайгаа яаж арчлах юм, яаж тэрийгээ өнжмөл дээр нь юу тарьж байгаа юм? Энэ дээр Хөдөө аж ахуйн яам мэдээлэл нь ямар байгаа бол?

Гуравдугаарт нь энэ Оросын Холбооны Улс улсаас л ихэвчлэн тэр гурил орж ирээд байсан. Яг гадаад нөхцөл маань ямар байдалтай болчхов? Энийг дахиад хэлээд өгөөч. Энэ экспортдоо бас хориг тавьчих шиг боллоо шүү дээ. Энийг дахиад тодруулаад хэлээд өгөөч. Ямар хортой юм руу бид нар явчихсан бэ гэдгийг сануулаад өгөөч гэж хэлэх гээд.

Ц.Даваасүрэн: Энхбаяр сайдын микрофон 4 номер.

Ж.Энхбаяр: Оросын Холбооны Улс энэ үүсээд байгаа хямралт байдалтай холбоотойгоор улаан буудай, малын тэжээлээ 7 сарын хүртэл гадаад улс оронд экспортлохгүй байх шийдвэр гаргачихсан байгаа. Одоо Оросын Холбооны Улсад байгаа дотоод үнэ дээр бид нар худалдан авалт хийгээд Монгол Улсын хил дээр ирэхэд 1 тонн улаан буудай сая хоёр зуун тавиас сая гурван зуун мянгаар орж ирэхээр байна. Манай дотоодын үнэ ноднингийн худалдан авалт сая тавин мянган төгрөг дээр үнэ гарсан.

Тэгэхээр ер нь гадаад хамааралтай байдал гэдэг маань ийм эрсдэлийг учрал гэдгийг бид сайн харлаа. Үндсэндээ үйлдвэрлэл унасан, газар тариалангийн талд ашиглаж байгаа талбайн хэмжээ багассан, бусад тосны ургамлын тариалалт энэ дээр нэмэгдсэн. Нөгөө талаас энэ гангийн байдалтай холбоотойгоор энэ эрсдэлийн түвшин өндөр болсонтой холбоотойгоор энэ газар тариалан компаниуд энэ жил талбайдаа хийх хөрөнгө оруулалтуудаа нэлээн татчихсан. Төмс дээр ч тэгж гарлаа, хүнсний ногоон дээр ч тэгж гарлаа, малын тэжээл дээр ч тэгж гарлаа. Ялангуяа малын тэжээл 144 мянган га тарихаас дөнгөж 30 мянган га, 100 мянган гагаар багаслаа гэсэн үг.

Яагаад гэвэл малын тэжээл маань улаан буудайн тэжээл тариалалтаа дагаж хийгддэг. Тэгэхээр энэ салбарын технологийг ийм тарилт явж байсан процессыг саяын хууль нэлээн хөдөлгөчихсөн. Энэнтэй холбоотойгоор бодитой эрсдэл үүсчихсэн. Тэгэхээр одоо энэ хуулийг хэлэлцээд батлагдвал бид өвлийн бэлтгэл ажилдаа орох, үлдэж байгаа цаг хугацаанд бид нарт 10 хоног л байна. 10 хоногт жоохон малын тэжээлийг эрчимжүүлэх бололцоо байгаа. Улаан буудайн үр тариан тариалалт таригдаад дуусчихсан, болц гүйцэхгүй. Одоо зөвхөн ногоон тэжээл тарихад жоохон 10-аад хоногийн нөөц байна. Энэ 10 хоногийн л идэвхжүүлэлтийг маш яаралтай хийж байна. Тэжээлийн тарилтыг нэмэгдүүлэх ийм ажлуудыг яамнаас зохион байгуулж байна.

Ц.Даваасүрэн: Хариулчихсан уу? Батболд гишүүн тодруулъя.

Р.Батболд: Улаан буудайн тариалалттай холбоотойгоор тэжээлийн асуудлууд бас их хүндрээд эхэлнэ. Тэгэхээр хуучин туслах аж ахуй гэж яриад байдаг байсан энэ шувуу, гахай, тахианы энэ фермерүүд чинь одоо бүр үндсэн үйлдвэрлэл болоод явчихсан. Тэрэнд чинь тэжээлүүд бүр их хэмжээгээр хэрэгтэй болдог болчихсон ийм байдалтай байгаа шүү дээ. Тэгэхээр ирэх жилд гэх юм уу энэ намраар эхлээд энэ тэр гахай, тахианы аж ахуйнуудад ер нь хэр цохилт болох бол? Энэ тэжээлийн асуудал нь аль зэрэг хүндэрч байгаа бол энэ? Багасах уу гэдэг дээр хариулт өгөөч.

Ц.Даваасүрэн: Хариулъя 4 номерын микрофон.

Ж.Энхбаяр: Тантай санал нэг байна Батболд гишүүн ээ. Үндсэндээ улаан буудайн үйлдвэр л унахаар тэжээлийн гарц багасаад эхэлнэ. Тэжээл багасаад ирэхээр гахай, тахиа, шувуу, сүүний аж ахуй, тэжээлийн дутагдалд орно. Энэ 150-аад мянган тонн үндсэндээ үр тариа дутна гэдэг чинь тэрний 30 хувь буюу 50 мянган тонн тэжээл байхгүй болно л гэсэн үг. Тэжээл байхгүй болохоор шувууны, өндөгний үйлдвэрлэл, гахай, сүүний аж ахуйн дээр үнэтэй болно л гэсэн үг. Импортын хамаарал нэмэгдэнэ, ахиад бид гаднаас авахаас аргагүй байдал үүснэ.

Хөдөө аж ахуйн салбар гэдэг маш эмзэг харилцан хамаарал бүхий ийм гинжин том хэлхээ. Цогцоор нь авч үзэхгүй бол нэг хэсгийг нь сугалж нэг хэсгийг нь ингэж хөдөлгөснөөр бусдад ийм сөрөг ийм нөлөөлөл үзүүлдгийг сая энэ дээр их тодорхой анзаарагдаж байгаа.

Нөгөө талаас зуншлага жоохон гайгүй байгаа Дорнод, Сүхбаатарт бид нар хадлан тэжээлийн ажлыг яаралтай зохион байгуулах чиглэлээр Улсын онцгой комисс дээр ажиллаж байгаа. Баруун бүс, Ховд, Баян-Өлгий, Увс маш хүчтэй гандуу байна. Дундговь аймаг.../минут дуусав./

Ц.Даваасүрэн: Батжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Батжаргал: Байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болгох тухай хууль дахиж орж ирж байна. Энэ хуулийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжээд мэргэжлийн Байнгын хороо, Төсвийн байнгын хороо ахиухан дэмжээд ажиллалчихмаар байна. Энэ Монголын үндэсний эрх ашиг, бүхэл бүтэн салбар, амь амьжиргаандаа гай тарьсан төрийн бодлого энэ явуулаад байгаа үйл явцаа ер нь бид зохих ёстой. 2023 онд 443 мянган га-д улаан буудай тариалж байсан бол энэ жил 264 мянган га буюу 40 гаруй хувиар буурчхаад байгаа юм. Бид ярихаараа зэрэг өмнөх онтойгоо харьцуулсан юм яриад 85 хувьтай энэ тэр гэж ингэж яриад байхаар зэрэг энэ ойлголтын зөрүү яваад байх шиг байна гэж.

Цаашид энэ асуудлыг бид аль болохоор гаргахгүй байх талаар энэний хор уршгийг нэлээн сайн ярьцгаахгүй болохоо байсан байна. Энэ Монголын төр засаг энэ салбарынхан 100 гаран жил ноцолдож байж өнөөдрийн энэ түвшин рүү авчирсан. 2-хон жил бодлогын алдаа гаргахад үйлдвэрлэлээ 50 хувь унагаж чадаж байгаа байхгүй юу бид. Дахиад 1 жил явах юм бол үндсэндээ техник ч үгүй болно, технологи ч үгүй болно, ажиллах хүч ч үгүй болно. Би хэдэн биедээ нэр өгөөд байдгаа бас болихыг хүсмээр байгаа юм. Энд юм ярьсан улсыг хэдэн гурилын үйлдвэрүүдийн кармад орчихсон мэтээр юм яриад байдаг. Тэгж яриад байгаа улсууд яах аргагүй импортлогчдын буюу гадныхны кармад орчихсон улс юм билээ.

Өнгөрсөн жил 64 мянган тонн гурил улсын хилээр оруулж ирсэн. 2 компани 10 гаруй, 10 гаруй мянган тонныг оруулж ирсэн. Би сая Гаалийн газраас мэдээлэл аваад энд орж ирж байна. Тэр 2 компани 1 нь одоогийн байдлаар он гарснаас хойш одоогийн байдлаар 3.2 мянган тонн, нэг нь 2.5 мянган тонн буюу үндсэндээ 6 мянган тонн гурил оруулаад ирчихсэн байгаа байхгүй юу. Тэр 20 мянган тонн гурилын 50 хувийг бараг 2-хон компани оруулж ирж байгаа. Эндээс харахаар юу гэж буугаад байна вэ гэхээр зэрэг гадныхны буюу импортлогч нарын гар, хөл болоод давхиад байгаа улсуудыг жоохон хазаардахгүй бол энэ асуудал цаашаагаа явахгүй нь.

Тийм учраас яам энэ тооцоо судалгаан дээрээ нэлээн тулгуурлаж тэр том импорт хийгээд байгаа компаниуд энэ тэрнийхээ нэр ус эд нарыг жаахан дуугармаар байна. Энэ үндсэндээ энэ Монголын үндэсний сөрөн тэсвэрлэх чадвар, энэ ард иргэдийн амь амьжиргаанд нэлээн томоохон хохирол авчирч байна. Үүнийг бид ер нь тал талаасаа нэлээн зоригтой дуугарахгүй бол болохоо бай.../минут дуусав./

Ц.Даваасүрэн: Тэр гурил импортлоод байгаа 2 том компанийн нэрийг хэл гэж байна. 4 номерын микрофон. Энхбаяр сайд. тэр импортын компани.

Ж.Энхбаяр: Ноднин жил 64 мянган тонн, он гараад 16 мянга байх нийт орж ирчихсэн одоо энэ онд, он гараад 18 мянган тонн 60, 70, 80-аад мянган тонн буюу 100 мянган тонн улаан буудайн дотоодын үйлдвэрлэл явуулах бололцоог хязгаарласан ийм л импортын байдалтай байна. Үнэхээр дэндүү харамсалтай л ийм үйл явдал болсон. Үнэхээр салбар маш хүчтэй доргисон. Энэ салбарт хөрөнгө оруулж байсан дотоодын хөрөнгө оруулагчид итгэлийг, урам зоригийг их хугалсан. Тэрний үр дүн энэ бүх төрлийн таримал дээр ухарчхаж байгаа юм. Ямар их зорилтот ажил хийж байж бид нар энэ 20, 21, 22, 23 онд ингэж үндсэндээ дотоодоосоо төмс, хүнсний ногоогоо хангаад улаан буудайгаа хангаад гурилаа дотоодын үйлдвэрлэлээр 100 хувь хангаа хангаад энэ чинь манай их том ололт, амжилт байхгүй юу. Энийг бид нар 2 жилийн дотор 50 хувиар л унагаачихлаа л даа.

Энийгээ дагаад өсөж байсан аж ахуйнууд эрчимжсэн гахай, тахиа, шувуу, өндөг, сүүний аж ахуйнуудын эдийн засагт нэлээн хүндрэл учирна. Энэ ургацын байдал унана гэдэг чинь орлого унана, орлого унана гэдэг чинь ажлын байр хадгалагдахгүй гэсэн үг. Улсууддаа цалин өгч чадахгүй, технологийн шинэчлэл хийж чадахгүй, зээл төлбөрөө төлж чадахгүй, дараагийн гинжин ийм санхүүгийн хямралт байдал руугаа энэ салбарыг түлхэж байгаа. Тэгэхээр энэний хор уршиг ингээд залруулагдахгүй. Ахиад 2 жил, 3 жилийн бид нарын ажлыг л нэг талдаа үр өгөөжгүй болголоо. Ахиад 2, 3 жилийн хугацаа алдах хэмжээнд л орууллаа. 2026 оны энэ улсын төсөв дээр энэ бодлогуудаа ахиад л хийгээд л оруулж ирнэ дээ. Энэ дээр гишүүд маань дэмжлэг үзүүлээрэй л гэж.

Ц.Даваасүрэн: Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Намрын ургац хураалтын төсөөлөл чинь нэлээн өөр болох байх. Энэ байгаль цаг уурын байж байгаа царай, ер нь Монголчууд юмнаас жоохон сэжиглээд байдаг юм. Тулга тойрсон явган хэрүүлтэй айл өөдөлдөггүй гэж. Газар тариалангаа тойроод бүтэн жил явган хэрүүл хийцгээж байгаа байхгүй юу. Тэрнийх нь уршиг энэ. Одоо болих ёстой. Энэ хэрүүлээсээ салах ёстой.

Тийм учраас энэ намрын хэрэгцээт гурилын будааны тооцоолол юмнуудаа нарийсгаж үзэхгүй бол энэ цаг агаарын байж байгаа царай бол би ер нь 130, 40 мянгаас илүү тийм хүнсний улаан буудай хурааж авах юм уу, үгүй юм уу би ер нь ойлгохгүй байгаа. Нэг.

Хоёрдугаарт энэ үлдэгдэл байж байгаа будаан дээрээ тооцоолол, судалгаануудаа хийгээд улсын нөөцдөө 100 мянгаа хүргэж авч чадах юм уу, үгүй юм уу бид хэд? Би энэ ган, гачиг гэдэг юм уу, бас гадаад нөхцөл.../минут дуусав./

Ц.Даваасүрэн: Санал хэлчих үү? 4 номер Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ хэрвээ хууль батлагдвал хуулийг дагаж Улсын Их Хурлын тогтоолын төсөл гарах учиртай. Тэн дээр заалтууд орсон. Энэ дотор стратегийн нөөц бүрдүүлэх зорилгоор 100 мянган тонн улаан буудайн нөөцийг бүрдүүл гэдэг ийм үүргийг Засгийн газарт Улсын Их Хурлаас өгөхөөр зохион байгуулж байгаа. Мөн баруун аймгийн маань гишүүдийн яриад байдаг баруун бүс нутгийн газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх, гурил тэжээлийн тогтвортой байдлыг хангах,

үнийн өсөлтөөс инфляцад нөлөөлөх нөлөөллийг бууруулахтай холбоотой авах арга хэмжээнүүд гээд ийм үүрэг даалгавруудыг бас давхар энэ хэрвээ хууль дэмжигдвэл Их Хурлын тогтоолын төсөл бас өргөн барьж хэлэлцэгдэх болно.

Тэгэхээр үнэхээр энэ өнөөдрийн тарилт хийсэн олон жилийн дундаж ургацтайгаа тооцоод бид нар ийм тоо гараад байгаа юм. Гэтэл ургац буурах нь тодорхой болчихлоо. Тэгэхээр бид энэ ургацын.../минут дуусав./

Ц.Даваасүрэн: Энэ асуудлаар ч бид нар уг нь 3, 4 хэлэлцүүлэг хийсэн дээ.

Гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүдийн нэрийг авъя.

Алга байна.

Би гишүүний хувьд үг хэлчихье. Тэгэхээр энэ гурилын татварын асуудлыг ер нь анх гарч байхад нь хүртэл Хөдөө аж ахуйн сайд нь ч хүртэл хэлж байсан байхгүй юу. Дотоодын үйлдвэрлэгч нарт сөрөг нөлөөлнө өө гээд. Тэгээд л хүчээр энийг аваачаад л баталчихсан. Яг хор уршиг нь гарч ирж байгаа байхгүй юу. Наад зах нь дотоодын үйлдвэрлэгч нарын итгэлийг алдаж байгаа нь үнэн. Гаднын хөрөнгө оруулалтын тухай бүүр ярих ч юм байхгүй. Бусад салбар ч гэсэн энэ чинь тэгж л ойлгодог шүү дээ. Монголчууд тогтворгүй юм байна, доороо бодлогоо өөрчилдөг юм байна гэдэг ийм мессежийг өгнө. Энэ нөгөө талаар валютын нөөцийг гадагшаа л алдах байхгүй юу. Гурил ч болсон бай, мөн малын тэжээл ч болсон бай гаднаас оруулж ирэх гэхээр чинь валют л урсана шүү дээ.

Тийм учраас бас л валютын л гадагшаа алдах. Нөгөө талаар хараат болно. Гурилын хараат болно. Гурилаа гаднаас авч иддэг болно гээд ийм олон хор уршигтай юман дээр л бид нар болчимгүй алхам хийчихсэн. Одоо тэрийгээ эргэж яриад л байж байгаа юм л даа.

Тэгэхээр Энхбаяр сайд аа энэ дээр юм анхаараарай гэж баруун аймгийн гишүүд л энэ дээр чинь түрүүн унахад нөлөөлчихсөн шүү дээ чуулган дээр эцсийн хэлэлцүүлэг дээр. Баруун аймагтай тэр сангийн аж ахуйнуудын тариалан эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийг тариаланчдыг дэмжих энэ тусгай бодлого явуулахгүй бол. Тэр төв рүү татаад байна гээд байгаа чинь байна шүү бас нэг үндэслэл байлаа шүү. Манай аймгийн Тосонцэнгэл сумын тэр хүнсний ногооны манай аймгийн 50 хувийг хангадаг Тээл байх даа. Тэнд 70 оны усалгааны системийг нь сольё гээд өнгөрсөн жил мөнгө тавьсан байсныг та нар өөрчилчихсэн байна лээ шүү дээ. Тэгээд төв рүү татчихсан байна лээ шүү дээ. Энд надад хариу өгөөч албан ёсоор. Тэр уг нь манай аймгийн 50 хувийг хангадаг аж ахуйн нэгж байхгүй юу хүнсний ногооны. Тэгсэн тэр маань байхгүй болчихсон байна лээ. Би сая харин ашиглалтад орчихсон юм болов уу гэсэн чинь байхгүй. Тэгээд би сураг сонссон чинь та нар өөрчилчихсэн байна лээ шүү дээ гэх мэтийн. Ер нь бол бас энэ зах хязгаарынхаа аж ахуйн нэгжүүдийг жоохон анхаарахгүй бол болохгүй. Тэр Баруунтурууны сангийн аж ахуй байна уу, ямар аж ахуйн нэгжүүд байна тэрийг нь дэмжих тал дээр анхаараад явчихвал болох байх гэж.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Үгүй ээ энэ чинь дэг зөрчигдөнө. Санал хураалт явуулна гишүүд ээ.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Энийг хүчингүйд тооцно уу энэ чинь. Нээрээ шинэ дэгээр бэлтгэж байж дараа нь санал хураалт явдаг болсон. Энийг хүчингүй. Гишүүдээ санал хураалтад бэлтгэе. Хөөш ингэхээр чинь гарах. Санал хураахад бэлэн болсон байна.

Гаалийн албан татвар төлөх тухай хуулийн төсөл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээлээр хэлэлцэхийг дэмжье гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 18 гишүүн оролцоод 14 гишүүн дэмжиж, 77.8 хувиар хэлэлцэхийг дэмжлээ.

Гаалийн алба хөөш гишүүд ээ байж байгаарай. Одоо 1 тогтоол байгаа. Хөөе амархан тогтоол байж байгаа.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлаар хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн унших уу? Цогтбаатар гишүүн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулъя.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэж дууслаа.

14.13 цаг

Хоёр дахь асуудал. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Төсвийн байнгын хорооны 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 6 сарын 25-ны өдөр зохион байгуулахаар товлож, сонгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Дамдиннямыг томилсон.

Байнгын хорооны тогтоол гарсан. Сонгол даргалагчаар томилогдсон гишүүнээс хүсэлт гаргасны дагуу Байнгын хорооны тогтоолд өөрчлөлт оруулан нэр дэвшигчийн сонгол даргалагчийг өөрчлөхөөр “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд танилцуулъя.

Байнгын хорооны тогтоол.

Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалтыг үндэслэн Төсвийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонгол даргалахыг сонгох тухай Төсвийн байнгын хорооны 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 14 дүгээр тогтоолын 2 дахь заалтын Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням гэснийг Батжаргалын Заяабал гэж өөрчилсүгэй.

Ийм тогтоол байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна.

Үг хэлэх гишүүн байна уу?

Алга байна.

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Төсвийн байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 11 гишүүн дэмжиж, 61.1 хувиар тогтоолын төсөл дэмжигдлээ батлагдлаа.

Төсвийн байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа. Баярлалаа гишүүд ээ.

14.15 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР